

“БЗӨБЦТС” ТӨХК-ИАС ЗОХИОН БАЙГУУЛСАН ОЛОН НИЙТИЙН АЖЛЫН ТАЙЛАН

Тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөн

Экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, ногоон хөгжлийг дэмжих зорилготой “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд энэ оны тав, есдүгээр саруудын Бямба, Ням гарагуудад мод тарих үндэсний өдрөөр компанийн хэмжээнд 5300 мод (гүйлс, буйлс) тарьж ургуулан, арчилж хамгаалж байна.



Бүх нийтийн цэвэрлэгээнд нэгдлээ

Улаанбаатар хот болон орон нутагт 2025 онд зохион байгуулагдсан 4 удаагийн бүх нийтийн цэвэрлэгээнд төв компани, 5 салбарын нийт ажилтнууд хамрагдаж байгууллага тус бүрийн эзэмшлийн 50 м хүртэлх нийтийн эзэмшлийн зам талбайг мөн хуваарьт газрыг цэвэрлэж, үүсмэл хогийн цэгүүдийг ачиж зайлуулав.



Хөдөлгөөн эрүүл мэнд

Баянхонгор аймагт зохион байгуулагдсан Монголын Бүх ард түмний спортын 16-р их наадамд Багануур дүүргийг төлөөлөн оролцсон сагсан бөмбөгийн эмэгтэй баг тамирчдын бүрэлдэхүүнд нярав Б.Аззаяа сонгогдож оролцсон бөгөөд багийн бэлтгэл сургуулилт хийх боломжийг бүрдүүлэн дэмжиж ажилласан. Мөн баг тамирчдад амжилт хүсч, санхүүгийн дэмжлэг үзүүлсэн ба тус тэмцээнээс хүрэл медаль хүртэж, амжилттай оролцсон.



Хэнтий аймгийн Засаг даргын тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн харьяа байгууллагуудын хооронд 4 төрөлт спортын наадам зохион байгуулсан комисст орж ажилласан. Тус арга хэмжээнд 9 багийн 80 гаруй тамирчид оролцон Манай салбарын баг хамт олон 2-р байр эзэлсэн.



Эрүүл мэндээ эрхэмлэх, зөв дадал эзэмшүүлэх ажлын хүрээнд ажлын байранд өглөөний дасгал хөдөлгөөнийг өдөр бүр 30 минут тогтмол хийж, ажилтнуудын эрүүл мэндийг эрхэмлэн ажиллаж байна.



Нийгмийн хариуцлагын хүрээнд

Тулгар төрийн 2234 жил, Их Монгол улсын 819 жил ардын хувьсгалын 104 жил, Дундговь аймаг байгуулагдсаны 83 жил, Мандалговь хот байгуулагдсаны 60 жил Сайнцагаан сум байгуулагдсаны 101 жилийн ойн баяр наадмыг угтан төв цэнгэлдэх хүрээлэнгийн зарим хэсэг, сур харвааны талбайн зүлэг дэвсэх тохижилтын ажлыг 2025 оны 07 сарны 04 өдөр хийж гүйцэтгэв



Нийслэлийн Багануур дүүргийн гэр хорооллын ахуйн халаалт бүхий, цахилгааны өндөр хэрэглээтэй 36 айл өрхөд биечлэн очиж, байшингийн дулаан алдагдлыг нь тусгай багажаар шалгаж тодорхойлон, эрчим хүчний хэмнэлттэй ухаалаг хэрэглээг нэвтрүүлэх, галын эрсдлээс сэргийлэх, эрчим хүчний зөв зохистой хэрэглээний талаар зөвлөмж мэдээллийг хүргэлээ.

Хүүхэд багачуудыг спортын замналд хөтөлж, зорилго тэмүүлэлтэй шинэ үеийг бүтээхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Багануур дүүргийн Гүн галуутай цогцолбор сургуулийн нэрэмжит U18 насны ангиллын волейболын улсын аварга шалгаруулах тэмцээн Багануур дүүрэгт зохион байгуулагдсан. Тус тэмцээнд оролцсон аймаг, дүүргийн шилдэг 16 багийн 220 гаруй тамирчдаас шалгарсан эрэгтэй, эмэгтэй “Шилдэг тоглогч” -ийн шагналд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллав.

Нийгмийн хариуцлагын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх үүднээс Багануур ЦТСС-ын ойр орчим дахь нийтийн эзэмшлийн зам талбайн аюул эрсдэлийг арилгах, ногоон байгууламжийг бий болгох, хамгаалах ажлыг зохион байгуулав. Аюулгүйн үүднээс замын хайс хашлагыг цэвэр эко мод болон олсоор шинэчлэн хийж, гүйцэтгэсэн.



Салбарын Залуучуудын зөвлөлийн холбооноос “ХҮҮХЭД ♡ ГЭРЭЛТ ИРЭЭДҮЙ” аяныг дотооддоо өрнүүлж, дүүргийн 1, 2, 5 дугаар хорооны бяцхан 3 сурагчид хичээлийн дүрэмт хувцас болон цүнх бусад хэрэгсэл бэлэглэлээ.



Дорноговь аймагт 2025 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр зохион байгуулагдсан “Тэнгэрийн хутагт” фестивалд салбарын нийт ажилтнууд бэлтгэл ажил болон зохион байгуулалтад дэмжлэг үзүүлж хамтран ажиллалаа.



